

Монгол дахь Пазырыкийн соёлын уналгын адууны тоног хэрэгсэл

Дунбүрээгийн Батсүх^{1,*}, Ганболдын Энхбаяр²

Товч агуулга: Монгол Алтайн нурууны баруун хэсэгт 2005-2018 оны хооронд 50 орчим пазырыкийн соёлын оршуулгын байгууламж малтан судалсан бөгөөд эдгээр байгууламжаас илэрсэн уналгын адууны тоног хэрэгслийн судалгааг бүхэлд нь тоймлон авч үзэв. Ингэхдээ хил залгаа бүс нутгуудад малтан судлагдсан пазырыкийн соёлын уналгын адууны зарим тоног хэрэгсэлтэй харьцуулан үзсэнээрээ Монгол Алтайн бүс нутгийн пазырыкийн соёлын нэгэн салаа сэдвийг нэгтгэж байгаагаараа ач холбогдолтой юм. Цаашид тухайн сэдвийг лавшруулан авч үзсэнээр эртний нүүдэлчдийн адууны соёлын судалгаанд онцгой ач холбогдолтой баримт материал хэрэглэгдэхүүний жинхэнэ ач холбогдлыг илүү тодруулах боломж байна.

Түлхүүр үг: Монгол, Алтай, Пазырыкийн соёл, уналгын адуу, эмээл, хазаар, чимэглэл

Удиртгал

Пазырыкийн соёл хэдийгээр бүтэн адууны оршуулга илэрдгээрээ алдартай боловч булш бүрээс адууны оршуулга ба түүнийг дагалдсан адууны тоног хэрэгсэл гардаггүй. “Язгууртны” гэгддэг том булшнууд ба “дунд” ангиллын булшнуудаас бараг бүгдээс нь адууны оршуулга гарсан байдаг бол “жижиг” ангиллын зарим булшнаас гарахгүй байх нь бий. Ихэнх адууг эрэгтэйчүүдийг дагалдуулан тавьдаг байсан бол эмэгтэйчүүд ба хүүхдийн оршуулгад харьцангуй цөөн тохиолдолд адууг дагалдуулжээ. Харин Катандагийн язгууртны булшнаас 22 адууны оршуулга илэрсэн нь хамгийн олон адуу нэг булшинд байсан тохиолдол болно. Орос Алтайд судалсан пазырыкийн соёлын 596 булшны 212-оос нь буюу 37,3% -с нь адууны оршуулга илэрсэн байна. Хэрэв 16 язгууртны булшнаас нийт 181 адуу гарсан бол дунд ба жижиг булшнаас 2-3 адуу гардгийг харгалзан үзвэл нийтдээ 450 адуу гарсан бололтой (Шульга 2015: 15). Монгол Алтайд малтан судалсан 50 булшнаас 57 бүтэн адуу илэрч нэг булшнаас адууны толгой, хүзүү, дал зэрэг илэрсэн байна.

Пазырыкийн соёлын булшинд хазаарыг үргэлж адууны оршуулгатай цуг тавьсан байдаг. Жирийн иргэдийн булшинд адуугаа хазаарласан байдалтай, бусад хэрэгслийг мөн зохих хэрэглээний байрлалд нь тавьдаг. Харин “язгууртны” том булшинд хазаар ба эмээлийг адууны оршуулгын дээр юм уу хажуу талд нь байрлуулдаг байна. Зөвхөн хамгийн эртний язгууртны

булшны нэг болох Башадар-2 булшнаас л бүх адуугаа хазаарласан байдалтай олджээ. Мөн өөр нэг өвөрмөц байрлал бол язгууртны Туэкта-1 булшинд хазаарыг адууны оршуулга ба давхар модон бунхны завсарт тавьсан байжээ. Хойлгын адуу ба тоног хэрэгслийн холбоо ийм ялгаатай байгаа явдлыг тайлбарлах нэгдсэн ойлголт үгүй байна. Зарим судлаач энгийн жижиг булшинд дагалдуулсан цөөн адууг уг эмээл хазаартай байгаа байдлаар нь оршуулгын ёслолын үед гаргаж булшинд байрлуулдаг байсан бол “язгууртны” том булшинд олон тооны адууг хойлголох бөгөөд тэдгээр адуу нь өөр өөр сүргээс өргөл болгож ирдэг тул тоног хэрэгсэл нь ч адуутайгаа шууд холбоогүй болдог байжээ хэмээн таамаглаж байна (Шульга 2015: 16). Жишээлбэл, Туэкта-1 булшинд 8 адуу оршуулсан боловч наад зах нь 28 хазаар дагалдуулсан байжээ. Мөн 19 эмээлийн нуман хяр олдсоноос үзвэл магадгүй 28 тооны эмээл ч байсан байж болно. Эдгээр адуунуудыг иж бүрэн тоногтой дагалдуулахын хамт нэгээс хоёр адууг сонгон бугын болон янгирын дүрт баг өмсүүлдэг байсан нь нэн сонирхолтой. Мөн Казахстаны археологич З.Самашев Берелийн малтлагаас янгирын модон эвэр бүхий баг илэрсэн байдаг (Самашев 2011: 131). Харин Орос Алтайн пазырыкийн дурсгалаас бугын дүр бүхий баг илэрсэн (Руденко 1948: Рис. 18). Монгол Алтайд малтан судалсан пазырыкийн дурсгалуудаас одоогоор багтай адуу илэрсэн тохиолдол байхгүй байна. Газрын хөрсний нөхцөл байдлаас шалтгаалан органик эдлэл хадгалагдах орчин янз янз байдаг билээ. Тус багтай адуунууд нь бэлгэдлийн хувьд сонирхолтой байна. Янгир болон бугыг нүүдэлчид уулын амьтан, магадгүй тэнгэрийн амьтан гэж үздэг учир нөгөө ертөнц буюу тэнгэрийн оронд хүргэдэг гэж итгэдэг байсан

¹ ШУА, Археологийн хүрээлэн

² МУИС, Археологийн судалгааны төв

* Холбоо барих зохиогч: dbatsukh2004@yahoo.com

<https://orcid.org/0000-0001-6890-096X>

бололтой. Тиймдээ ч тэнгэрийн орныг зорьж байгаа нэгэндээ дагалдуулсан адуунд янгир болон бугын баг өмсгөдөг байж. Тэр дундаа бугын тухай ойлголт нүүдэлчдийн нөгөө ертөнцийн тухай ойлголтын бэлгэдэл юм.

Монгол Өвөр Байгалын дүрслэлт буган хөшөөнд байдаг тэнгэр рүү дүүлж буй бугын загварчилсан дүрийн илэрхийлэл нь нөгөө ертөнцийн зүг замчлах тухай маш хүчтэй ойлголт билээ. Үүнээс гадна Монголын нууц товчоонд Чингис хааны угсаа гарлын тухай өгүүлэхдээ: ... дээд тэнгэрээс заяат Бөртэ чоно, Гуа марал ... хэмээн өгүүлдэг.

Нүүдэлчдийн ертөнцөд буга, янгир зэрэг уулын тураг амьтдыг нөгөө ертөнцийн замаар явдаг тэнгэрийн амьтад хэмээн биширдэг ойлголт урт удаан жилийн настай гүн утгатай байсныг эдгээр жишээнээс харж болох биз ээ. Пазырыкчуудын хувьд оршуулгад дагалдуулсан адуугаа хоньчилон хэвтүүлж толгойг эрүүгээр нь дэвсүүлэн тавьсан байдаг. Оршуулгад дагалдуулсан адуугаа бүтэн тоног зүүсгэлтэй тавих бөгөөд тэдгээрийн чимэглэл дунд зөвхөн оршуулгад зориулан урласан бэлгэдлийн шинжтэй хэрэглэлүүд голлох байр суурьтай байдаг.

Пазырыкийн түрүү үеийн буюу НТӨ VI-V зууны булшинд бодит хүрэл ба эвэр хэрэгсэл дагалдуулсан байдаг бол НТӨ IV-III зууны хожуу үе болж ирэхэд модон ба арьсан хуулбар дагалдуулах болжээ. Иймээс мөнх цэвдэггүй булшинд зөвхөн төмөр амгай ба модон хуулбарыг бүрсэн алтан юм уу тугалган ялтас, дугтуйнууд нь л илэрдэг байна. Пазырыкийн адууны тоног хэрэгслийг хазаарын багц ба эмээлийн багц хэмээн ангилдаг. Хазаарын багц дотор амгай, зуузай, хазаарын сур ба хазаарын чимэглэлийн унжлагууд багтдаг бол эмээлийн багцад эмээлээс гадна хударга, хөмөлдөргийн зүйлс, тэдгээрийн төмөрлөг, модон ба эвэр чимэглэл багтана. Бид пазырыкийн соёлын хазаар ба эмээлийн багцын талаар ерөнхий судалгаанд


тулгуурлан Монголоос илэрсэн хэрэглэгдэхүүнийг тайлбарлав.

Хазаарын багц

Уналгын адууны залж жолоодох хамгийн чухал хэрэгцээт зүйл бол мэдээж хазаар юм. Пазырыкчуудын хазаарын багцад төмөр, хүрэл, яс, мод, сур, утсан эд, алт зэрэг ордог байна. Бүтцийн хувьд амгай, зуузай, шагай шанаа, шил, сагалдарга, сэжим, магнай зэрэг өнөөдөр ч хэрэглээнд байгаа хазаарын үндсэн бүрэлдэхүүнийг хадгалсаар байгаа нь археологийн судалгаагаар нэгэнт нотлогдоод байна. Хазаарын амгайны үндсэн материал нь төмөр болон хүрэл байдаг. Харин хазаарын зуузайг төмөр, хүрэл, яс буюу эвэр зэргээр урлахаас гадна зөвхөн оршуулгад зориулж модоор хийх нь түгээмэл байжээ.


Хазаарын толгойг ихэвчлэн боловсруулсан шир буюу сураар хийхээс гадна чимэглэлүүдийг нь утсаар хэлхэж хазаарын хэлбэр үүсгэсэн байдаг. Тухайн утсаар хазаарыг төлөөлүүлдэг байсан бололтой. Хазаарт олон төрлийн модон чимэглэл хийдэг бөгөөд тэдгээр чимэглэлүүдэд нарийн утас сүвлэж хэлхдэг байсныг модон чимэглэлүүдийн нүхнээс төвөггүй мэдэж болно. Тэдгээр олон салаа утга санаа илэрхийлэхүйц баялаг өгүүлэмжтэй модон чимэглэлүүдийг зарим тохиолдолд алтан ялтсаар бүрж чимэглэдэг ажээ. Хазаарын магнайны хувьд суран оруулгаас гадна утсан оруулга оруулж духавч, халз, цоховч зэрэг чимэглэлүүдийг тогтоох зорилгоор утсан оруулгыг магнай болгон ашгилдаг байсан нь Орос Алтай, Казахстанд хийсэн малтлагуудаас нэгэнт тодорхой болсон.

Жолоо, цулбуур. Хазаарын багц дотор морийг залах ба батлан тогтоох хэрэгсэл нь жолоо цулбуур хоёр болно. Жолооны тухайд хамгийн эртний энгийн амгайгүй хазаараас эхлэн бий болсон бол цулбуур



Зураг 1. Пазырыкийн морины хазаарын бүдүүвч зураг. (Грязнов 1950: Рис. 20)

Тайлбар: 1 – амгай, 2 – зуузай, 3 – шанаа, 4 – сагалдарга, 5 – хамар, 6 – цоховч, 7 – жолоо, 8 – цулбуур



Зураг 2. Пазырыкийн морины хазаарын сурыг зангидах хэлбэрүүд (Степанова 2006: Рис. 18)


арай хожуу үед үүссэн бололтой. Цулбуурыг скифийн үеэс эхлэн өнөөг хүртэл морины амгайны зүүн цагариганаас зүүдэг байжээ (Руденко 1960: 224). Цулбуурын үүрэг хэрэглээ нь морийг уяж бэхлэх, хөтлөн явахад хэрэглэгдэнэ. Скифийн Куль-Оба булшнаас гарсан нэгэн ясан ялтас дээр сийлбэрлэсэн зурагт морио алдаад цулбуураасаа чирэгдэж байгаа скиф хүнийг дүрсэлжээ (Зураг 3). Монголын пазырыкийн булшнаас жолоо цулбуур одоогоор илрээгүй байна.

Амгай. Амгайны үндсэн хэлбэр нь жижиг сэнжээр хэлхэгдсэн хоёр чөмөг жигүүр жигүүртээ 3,2-3,6 см голчтой битүү гархин сэнжтэй байдаг. Жолоо, цулбуур, зуузаа, том гархин сэнжнүүдийг дугуй хэв хавчуулан давтаж гаргадаг байсан нь илэрхий харагддаг. Амгайны бэлдэц төмрийг давхарлахдаа хэлхэх, бэхлэх гархин сэнжнүүдийг үүсгээд ирмэгүүдийг дарж дугуйруулан давтсанаараа хийц нь орчин цагийн амгайнаас онцлогтой болдог. Орчин цагт жолоо, цулбуур бэхлэх том цагариг нь амгайнаасаа тусдаа

хэсэг болон хөгжсөн бөгөөд орчин цагт цагариг нь зуузааны үүргийг давхар гүйцэтгэж гархин зуузаа хэмээн нэрлэгддэг.

Пазырыкчуудын амгайны хэмжээнүүд харилцан адилгүй том, жижиг хэмжээтэй байдаг бөгөөд Монгол Алтайн нуруу Баян-Өлгий аймгийн нутаг Хатуу, Сыргаль (Шар гол Д.Б), Цэнгэл хайрхан, Бага түргэний гол зэрэг дурсгалт газраас илэрсэн бүтэн амгайнуудад хэмжилт хийхэд нийт урт дунджаар 22,5 см бол чөмгүүдийн уртын харьцаа дунджаар 11,2×10,8 см хэмжээтэй байна.

Пазырыкчуудын хазаарын амгай бүтээх үндсэн түүхий эд нь төмөр байжээ. Хүрлээр амгай хийсэн цөөн тохиолдол байгаа бөгөөд манай улсын нутагт хүрлээр хийсэн амгай одоогоор илрээгүй байна. Хүрлээр хийсэн амгайны мушгимал өрөөсөн чөмөг Укокийн хөндийн Ак-Алаха 1-р булшнаас илэрч байсан (Полосьмак 2001: 53) бол Казахстаны Берелийн 10-р булшнаас нэг адууны хүрэл амгай, 71-р булшны 2-р адууны хүрэл амгай мөн 72-р булшны 1-р адууны



Зураг 3. Скифийн Куль-Оба булшны ясан ялтас дээрх морьтны сийлбэр зураг (Руденко 1960: Рис. 121)

хүрэл амгай тус тус илэрсэн байдаг (Самашев 2011: 75-77). Монгол Алтайн нуруунд малтан судалсан булшнаас илэрсэн амгайнууд 100 хувь төмөр байна.

Пазырыкчууд төмөр амгайны хэлбэр хийцийн хувьд тогтсон арга зүйн дагуу бүтээдэг уламжлалтай байсан нь Орос Алтай, Казахстаны Алтай, Монгол Алтайд тус тус малтан судалсан дурсгалуудаас нэгэнт тодорхой болсон. Амгайны бэлдэц төмрөө тал талаас нь цувьж дугуйруулан давтаад, давхарлаж нугалахдаа хөл, толгой талын жижиг, том гархин сэнжийг үүсгэж цутгуурынх мэт уусгаж давтсан байдаг. Тухайн арга барил нь хүннү нарын амгай хийх арга барилтай ижил бөгөөд онцлог тал нь гэвэл Хүннүгийн уналгын адууны амгайн чөмгийг ирмэгтэй буюу дөрвөлжин хэлбэртэй хийсэн байдгаараа ялгаатай юм. Энэ нь магадгүй тухайн ард түмний уналгын адууныхаа ааш аягтай харьцах хэрэглээний туршлагатай холбоотой байсан бололтой.

Амгайны ангилал. Монгол Алтайд малтан судалсан пазырыкийн оршуулгын дурсгалаас илэрсэн

амгайг хэрэглээний ба төлөөллийн гэж хоёр ангилж болно. Пазырыкчуудын хазаарын амгайны ихэнх нь хэрэглээний элэгдэлтэй илэрдэг бол цөөн тохиолдолд зөвхөн оршуулгад зориулсан төлөөллийн амгай хийдэг байсан байна. Төлөөллийн гэж үзэх шалтгаан нь тус амгайнууд хэрэглээний элэгдэл байхгүйгээс гадна маш нимгэн хавтгай төмрийг нугалж давхарлан амгайны чөмөг болгон боловсруулсан байдаг. Хэрэглээ талаас нь үзвэл амгай хийх үндсэн боловсруулалтыг орхигдуулж дутуу боловсруулалтай, хэт нимгэн төмөртэй, морины ам гэмтээхүйц ирмэгтэй ажээ. Адууныхаа аманд халтай зэргээс үндэслэн төлөөллийн амгайг оршуулгад зориулж орлуулан үйлдэх тохиолдол байсныг энэ нь гэрчилж байна. Тухайлбал, төлөөллийн амгайнд Сыргаль-I дурсгалын 1-р булшны №7, Хатуу-I дурсгалын 1-р булшны №6, Цагаан Салаагийн 6-р булшны №2 дугаартай амгайнуудыг тус тус дурдаж болно.

Эртний нүүдэлчдийн хазаарын амгайны чөмгүүд орчин цагийн нүүдэлчдийн хазаарын амгайтай

харьцуулахад харьцангуй богино хэмжээтэй байдаг. Учир нь урт чөмөгтэй амгай нь адууг залах үед жолоо татсан тал уруу хэлбийж гүйх нь элбэг байдаг байна. Энэ нь хөдөлгөөн дундах хугацаа хожих туршлагатай холбоотой байж болох юм. Өөр нэг сонирхолтой жишээ нь пазырыкчуудын хазаарын амгайны хоёр чөмөг нь урт, богино хэмжээтэй байдаг. Ер нь пазырыкчуудаар ч зогсохгүй хүннү нар, бүр цаашилбал дундад зууны үеийн монголчуудын хазаарын амгайны чөмгүүд урт, богино хэмжээтэй байдаг нь ч санамсаргүй хэрэг биш бололтой. Пазырык ба хүннүгийн хазаарын амгайны хоёр чөмгийн зөрөө ойролцоогоор 0,8-1 см орчим байна. Энэ нь богино зайд хурдтай хөдөлгөөн хийхэд зориулж үйлдсэн байх магадлалтай бөгөөд ялангуяа ойрын зайн тулаанд нэг гараар зэвсэг агсан тэмцэлдэх үед нөгөө гараар морио жолоодож хурдтай эргэлт хийх хэрэгцээнээс үүдэж жолоо атгадаг гар талдаа зориуд богино чөмөг хийдэг байсан байх боломжтой юм. Нөгөө талд яагаад үл ялиг урт чөмөг хэрэглэж байгаа тухайд асуулт гарч ирнэ. Мэдээж морины амыг халааж гэмтээхгүйн тулд амгай нь морины аманд бага зэргийн гүйлт хөдөлгөөнтэй байх шаардлагатай байдаг. Тиймээс зэвсэг агсаж буй гар талын амгайны чөмгөнд дээр дурдсан морины амны гэмтэл зовууриас сэргийлэх хэрэгцээт хэмжээг тооцоолон бүтээдэг байсан байх боломжтой.

Эртний нүүдэлчдийн тулалдааны давуу талуудын нэг онцлогийг морин дээрээс тулалдах чадвараар үнэлдэг. Тэгвэл түрүү төмөр зэвсгийн үеэс нааш морин дээрээс тулалдах тулаандаа зориулж технологийн хувьд нарийн арга боловсруулан хэрэглэж байсан нэгэн жишээг амгай бүтээх технологиос харж болно хэмээн үзэж байна.

Зуузай. Пазырыкчуудын уналгын адууны хазаарын зуузай маш сонирхолтой баялаг хэрэглэгдэхүүнтэй. Скифийн ертөнцийн амьтны загварт урлаг хийгээд дүрсний бэлгэдлийн онцгой илэрхийллүүдийг өөртөө шингээсэн байдгаараа онцлогтой юм. Монгол Алтайд малтан судалсан пазырыкийн дурсгалаас илэрсэн хазаарын зуузайнууд бүгд модоор урласан байна. Орос Алтайд малтан судалсан пазырыкийн дурсгалаас илэрсэн уналгын адууны зуузайнуудын дийлэнх нь модон зуузай байна.

Зуузайны ангилал. Пазырыкийн соёлын хазаарын зуузайг дүр байдлын хувьд амьтны, ургамлын, геометрийн дүрст гэж ангилж болно. Харин материалын хувьд эвэр болон модон гэж ангилах боломжтой. Монгол Алтайд малтан судалсан пазырыкийн дурсгалаас амьтны, ургамлын дүрст зуузай түгээмэл олдсон байдаг. Харин геометрийн дүрст хамаатуулж болох сэнс хэлбэртэй зуузай одоогоор Монголоос ганц олдод байгаа нь Олон гүүр (нуур)-ийн голын 10-р дурсгалт газрын 1-р булшнаас илэрсэн. Хазаарын модон зуузайнуудын хадгалалтын байдал материал талаас нь ч бодсон хэрэглээнийх байх үндэсгүй бөгөөд зөвхөн оршуулгад зориулсан төлөөллийн шинжтэй. Харин яс буюу эврээр хийсэн зуузай мөн тохиолдох бөгөөд эвэр болон ясан зуузай нь цэвэр хэрэглээнд байсан эд болох нь тодорхой юм. Учир нь эвэр зуузайнд хэрэглээний элэгдэл байдгаас гадна материалын хувьд нүүдэлчдийн хэрэглээнд саяхныг хүртэл түгээмэл байжээ.

Хүрэл зэвсгийн үеэс Түрэгийн үе хүртэлх нүүдэлчдийн хэрэглээнд эвэр болон ясан зуузайг түгээмэл ашиглагдаж байсан нь археологийн малтлагаар нэгэнт тодорхой болсон билээ. Тухайлбал эвэр, модон зуузайнуудад зэргэлдээ тэгш өнцөгт хэлбэртэй хос нүх гаргадаг бөгөөд энэ хос нүхэнд хазаарын шагайнаас салаалуулсан сурыг сүвлэж бэхлэх зориулалтай билээ. Харин пазырыкийн оршуулгын дурсгалд шагайнаас салаалдаг сурыг хоёр салаа модон үүсгүүрээр төлөөлүүлэн модон зуузайны хоёр нүхэнд бэхлэгддэг байхаар төлөөлүүлэн хийдэг. Монгол Алтайн нуруунд малтсан пазырыкийн оршуулгаас илэрсэн зуузайнууд грифоны буюу домгийн шувуу, ургамал, дэгрээ хэлбэрийн дүрслэлтэй зуузайнууд илэрсэн. Ургамлын дүрст зуузайнуудад нь хоёр болон нэг дэлбээт ургамал дүрслэгдэг. Харин Орос Алтай, Казахстанд малтан судлагдсан булшнуудаас илэрсэн хазаарын зуузайнууд дүр, дүрслэл олон төрөл зүйл бүхий баялаг өгүүлэмжтэй. Энэ нь мэдээж малтсан булшны зэрэг дэвийг илэрхийлэх байгууламжийн хэмжээ, тоо зэргээс шалтгаалан баялаг байх нь магадлалын хувьд тодорхой юм. Тухайлбал Орос, Казахстаны малтлага судалгаанаас илэрсэн пазырыкийн уналгын адууны хазаарын модон



Зураг 5. Монгол Алтайгаас илэрсэн хазаарын зуузайнуудын төлөөлөл. Сыргаль-III, Були-1, №36, 39


зуузайны амьтны төрөл зүйл нэн баялаг байна.

Грифоны толгойн дүрээр чимэглэсэн төлөөллийн зуузай бол пазырыкчуудын зуузайд түгээмэл тохиолдог дүрслэл билээ. Түүнээс гадна ургамал, дэгрээ буюу сэнс хэлбэртэй, аргал, янгир, хандгай, тас шувуу, дүр нь үл танигдах домгийн амьтан зэрэг олон төрөл зүйлт амьтан, ургамлын дүр шингээсэн зуузайнууд олджээ.

Пазырыкчуудын хазаарын зуузайны хоёр жигүүрт грифоны толгойн дүрслэлийг эсрэг зүгт хандуулан хосоор нь дүрсэлсэн байдаг. Тэдний амьтны загварт урлаг нь лавшруулан судалбал өөрөө бие даасан том сэдэв билээ. Утга зүй хийгээд бусад холбогдох тайлбар дутуу дундуур байгаа нь бид пазырыкийн амьтны загварт урлагийн гүнд орж ойлгож амжаагүй байгаагийн илрэл биз ээ.

Пазырыкийн амьтны загварт урлагийн дүр илэрхийллүүд оршуулгын зан үйлд нэвт шингэсэн байдаг. Тэдгээрийн утга бэлгэдэл нь энэ амьдрал, нөгөө ертөнцийн тухай ойлголтыг хамтатган илэрхийлж байдгаараа итгэл үнэмшлийн гүн гүнзгий утга учиртай.


Уналгын адууны тоног хэрэглэл дэх амьтны загварт урлагийн чимэглэлүүд нь мод, эсгий зэрэг эдээр хийгдсэн байх бөгөөд агуулгын хувьд модон эдээр хийсэн чимэглэлүүд нь зөвхөн оршуулгад зориулан хийдэг ажээ. Дээрх дүрүүдийг шингээсэн



Зураг 6. Пазырыкийн адууны хазаарын чимэглэл, унжлагууд (1-5 – Полосьмак 1994: Рис. 54, 60, 63, 64, 108; 6 – Шульга 2015: Рис. 33)

зуузайнуудыг бүгдийг оршуулгад зориулан модоор хийдэг нь өөрөө бэлгэдэл зүйн гүн утга агуулга, асар их хүндэтгэлийн илрэл юм. Эдгээр бэлгэдэл зүйн тухайд шууд тайлбарлах боломж хомс байгаа ч гэсэн учир зүйн үүднээс нь (логик) хөөн үзвэл итгэл үнэмшил, сүсэг бишрэлийн журам нь нарийн дараалал дэг ёсны дагуу оршуулгын эд зүйлсийг дагалдуулдаг дүр байдал, бэлгэдэл нь тэдний хүрээ хязгаар, тусгалаа олж буй орон зай зэргээр хэмжигдэж байгаа чимэглэлийн зүйлсээс тодорхой харагдаж байна.

Хазаарын чимэглэлүүд. Пазырыкчуудын хазаар чимэглэх үйл нь урлагийн өндөр түвшинд хүрсэн байсан нь археологийн хэрэглэгдэхүүнээс илэрхий харагддаг. Грифон болон ургамлын дүрслэлүүдийг тодорхой эмх цэгцтэйгээр хазаарын суран хэсэгт утсаар хэлхэх, хатгах байдлаар тогтоодог байжээ. Хазаарыг чимэглэхдээ бүхэлд нь чимэглэхээс гадна, суран зангилгаа уулзварууд дээр чимэглэдэг. Хазаарын чимэглэлүүдийг алтан ялтсаар бүрэх тохиолдол нийтлэг байжээ.



Зураг 7. Монгол Алтайн пазырыкийн дурсгалаас илэрсэн хазаарын чимэглэлүүдийн гар зураг: 1 - ургамлын дүрст, 2 - грифоны хос толгой дүрс

Грифон буюу алт хамгаалагчийн дүрслэлийг өөд өөдөөс нь харуулан дүрсэлсэн модон чимэглэл болон хоёр тал руугаа дэлбээлсэн далбагар том ургамлын дүрст чимэглэлээр хазаарын гадаргууг бүтэн чимэглэсэн байдаг. Мөн хүчирхэг махир хошуутай грифоны толгойн дүрслэл, далавчаа дэлгэсэн шувуу, нэг дэлбээт ургамлын дүрслэлүүдийг буулгасан модон чимэглэлүүдийг түгээмэл ашигладаг байжээ. Адууны духыг голлон байрлах цоховч, духавч, халз хэмээн чимэглэлүүдийг агуулгаар нь нарийвчлан ангилж болохоор байна.

Эмээл

Морины зөөлөн эмээл анх тал нутагт түрүү төмөр зэвсгийн үед үүссэн гэж үздэг (Степанова 2015b: 125). Энэ нээлт тухайн цаг үедээ технологийн томоохон дэвшил болсон бөгөөд морьтон цэргийн довтолгооны хүч ба хөдөлгөөнт байдлыг эрс нэмэгдүүлжээ. Эмээл гарснаар хүнд морин цэрэг бий болох нөхцөл бүрэлдсэнийг судлаачид хэлдэг.

Судлаачдын олонтоо дурдсанчлан түрүү төмрийн үе буюу Скифийн үед анхны эмээл бий болж өргөн дэлгэрсэн байдаг. Энэ нь хэдийгээр савх модон бүүргийн хатуулгатай боловч зөөлөн биетэй эмээлийн төрөлд орно. Учир нь дээрх савх мод өнцөг багатай матаастай, зөвхөн бүүргийн хэлбэрийг тодотгон бэхжүүлэх үүрэгтэй байсан бөгөөд хатуу модон хавтас байхгүй юм. Харин эсгий, ноос чихсэн хос арьсан жинтүүн хавтас ба суудлын үүргийг давхар гүйцэтгэж байсан онцлогтой. Пазырыкийн соёл ба тухайн цаг үеийн Шинжааны зарим дурсгалаас ийм хэлбэрийн эмээл цөөнгүй олдсон нь хэлбэр бүтцийн хувьд нэлээд ялгаатай боловч нийтлэг зүйл нь үл ялиг өндөрссөн бүүрэгтэй (заримдаа савх модоор бэхжүүлсэн) хос жинтүүнээс бүрдсэн байдаг. Эмээлийн бүрдэл хэсгийн бусад зүйлүүд, түүний дотор олом, хударга, хөмөлдөрөг зэрэг нь аль хэдийн бүрдсэнээр эмээл үүргээ сайн биелүүлж байсан гэдэгт эргэлзэх зүйлгүй.

Зөвхөн нүүдэлчдийн ертөнц төдийгүй тухайн цаг үеийн дэлхийн тэргүүлэх гүрнүүд болох Ром, арай хожуу үеийн Иранд ч дээрхтэй төстэй зөөлөн эмээл хэрэглэж байсан ажээ. Тиймээс ч НТ IV зууны үед хатуу дөрөө гарах хүртэл бараг мянган жил ийм хэлбэрийн зөөлөн эмээлийг Евроазийн эх газарт өргөн хэрэглэж байжээ. Энд дөрөө дөнгөж НТ VI зуунд аваруудын хамт Европт хүрсэн бол НТ VII зууны эхэн үеийн Сасанидын морьтнууд ч дөрөөгүй хэвээр байжээ (Амброз 1973: 81).

Алтай, Шинжаан, Умард Хятадын эмээл. Анхны нуруу унах эмээл Скифийн үед буюу НТӨ VII-II зууны үед бий болсон бололтой. Одоогоор илэрсэн хамгийн эртний эмээлүүд бүгд Евразийн зүүн хэсгийн скиф хэлбэрийн соёлуудын хүрээнд багтаж байна. Зураг

8-д Скифийн үеийн зөөлөн эмээлийн зарим сонгодог жишээг үзүүлсэн болно. Хэдийгээр тэргэнд хөллөсөн илжиг луусанд шоохой тавьсан зураг дүрслэл илүү эрт үед НТӨ XII-X зуунд таарч байх боловч мордож унасан зүйл үгүй юм (Степанова 2015: 125).

Хятадад морийг анхандаа тэргэнд хөллөж байгаад зөвхөн НТӨ IV зууны үед нуруу унадаг шинэ хэлбэрийг нүүдэлчдээс зээлэн авчээ (Goodrich 1984: 280). Байлдаант улсын төгсгөл үе буюу нарийвчилбал НТӨ 307 онд Чжао улсын У-лин ван “Түүхэн тэмдэглэл” сударт өгүүлснээр: “[Хятадын] уламжлалыг эвдэн ху нарын хувцсыг өмсөж морь унах, нум сумаар харвах зэрэгт суралцаж ... умар зүгийн линьху, лоуфань нарыг сөнөөв” (Таскин 1968: 37) гэсэн бол НТӨ I зууны үеийн Чжаньго цэ (战国策 “Байлдаант улсын төлөвлөгөө” зохиолд энэ үйл явдлыг маш дэлгэрэнгүйгээр У-лин вангийн ордонд болсон хэлэлцүүлэг ба харилцан яриа хэлбэрээр өгүүлсэн байдаг (Crump 1970: 296-303). Ямар боловч энэхүү үйл явдал бол Дундад орныхон Байлдаант улсын уламжлалт цэргийн тактикийг умардын маягаар хувьсган өөрчилж үүнээс хойш хоёр соёл иргэншлийн цэрэг дайны харилцааг эрс өөрчилсөн явдлын эхлэл болсон түүхэн хэрэг байжээ. Хятад хэлэнд морийг “нуруу унах” гэсэн утгатай “чи” (qí 骑) гэсэн ханз НТӨ III зуунаас өргөн хэрэглэгдэж эхэлсэн ч харьцангуй хожуу үед энэ соёл нэвтэрсэн болохыг зааж өгдөг. “Эмээл” гэсэн утгатай “ань” (an 鞍) гэсэн ханз ч яг энэ үеэс хэрэглэгдэж эхэлсэн байна (Goodrich 1984: 281, 287).

Байлдаант улсын сүүл Цинь гүрний эхэн үед хятадууд нэгэнт эмээл хэрэглэж байсан бөгөөд тэр нь скиф хэлбэрийн эмээл байсныг Цинь Ши Хуандийн онгоноос гарсан морины шавар шуумлаас харж болно. Энэ олдвор болон арай хожуу үед хамаарах хэдэн сонирхолтой эмээл Шинжаанаас илэрсэн байдаг. Юуны өмнө Субаши-I оршуулгын цогцолборын 10-р булшнаас гарсан эмээл (Зураг 8–3), Орос Алтайн Пазырыкийн язгууртны булшнаас гарсантай нэгэн адил нүүр ба бөгсөндөө нэмэлт хатуу унжлага чимэглэлтэй байна. Баруун Хань улсын үеийн шавар шуумал баримлуудад мөн адил бүтэцтэй эмээлүүд дүрслэгдсэн байх нь хөмөлдөрөгийг эмээлд бэхлэх аргаас бусад талаараа өмнөх үеийн Скиф ба Цинь Ши Хуандийн онгоны эмээлээс ялгарах зүйлгүй юм (Степанова 2014a: 238). НТ II зуун буюу Зүүн Хань улсын төгсгөл үе хүртэл ийм зөөлөн эмээл Хятадад хэрэглэж байсныг бид Швейцарийн Цюрих хотын Рийтберг музейд буй хүрэл морины эмээлээс харж болно (Зураг 8–1).

Харин Шинжаанд тухайн үед арай өөр бүтэцтэй эмээлүүд бий болсон байжээ. Хань улсын үед хамааруулдаг Шинжааны Лоулань 1-р булшнаас гарсан 13 см урттай эмээлийн бичил загвар (Зураг 8–4) хэдийгээр загвар төдий боловч хадгалалт маш сайтай

тул нарийн бүрдэл хэсгүүдийг ч харах боломжтой. Энэхүү эмээлийн эвэр бүүрэг нь эмээлдээ хэлбэр оруулах чухал үүрэгтэй болохоос гадна мэдээжийн хэрэг бэхлэгээний давхар үүргийг гүйцэтгэдэг байсан ажээ.

Пазырыкийн булшнуудын мөнх цэвдгийн бүсэд байгаа онцгой нөхцөл байдал нь органик эдлэлүүд түүний дотор органик эмээлийн хадгалалтад хосгүй таатай нөхцөл үүсгэсэн байдаг. Иймээс ч тухайн үеийн тал нутгийн аль ч соёлоос хавьгүй олон хэрэглэгдэхүүн энэ соёлд хамаарна. Зөвхөн Эрмитажийн музейд л гэхэд 70 гаруй эмээлийн хэсгүүд хадгалагдаж байна.

Пазырыкийн соёлын хүрээнд эмээлийн бүтэц ба хийцийн хувьд орон нутгийн болон он цагийн ялгаа ажиглагддаггүй юм. Гэхдээ хээ чимэглэл ба бусад чимэглэлийн хэсгүүдийн хувьд ялгаа бий. Судлаачид пазырыкийн эмээлийг үндсэн хоёр төрөл болгон ангилдаг. Эдгээр нь: 1) Нэгдүгээр төрөл: Пазырык-1 ба 2-р булшнаас гарсан эмээлүүд, 2) Хоёрдугаар төрөл: Пазырык-3, 4 ба 5-р булшнаас гарсан эмээлүүд болно (Руденко 1953: 161).

Нэгдүгээр төрлийн эмээл нь хос зөөлөвч үндсэн хэсэг нь болж түүний дээр доороос оёж хадсан эсгий тохом ба бүрээснээс бүрддэг байна. Эдгээрийн дээрээс суран олом дарж байдаг. Эмээлийн урд талд

нарийн сураар хийсэн хөмөлдөрөг бэхлэгдэж байдаг. Харин хударга нь битүү гогцоо хэлбэртэй байдаг тул хэмжээг нь тохируулах аргагүй зөвхөн угладаг байжээ (Руденко 1953: 164).

Хоёрдугаар төрлийн эмээл нь бүтцийн хувьд өмнөх төрөлтэй бараг адил боловч 10 см орчим өндөр бүүргээр ялгардаг. Үүний бүгдэд нь мод юм уу эвэр нуман тэлэгч байдаг ажээ. Мөн түүнчлэн эвэр чимэглэлийн унжлагуудтай байдаг нь онцлог болно. Энэ хэлбэрийн эмээлийн хударга нь энгийн гогцоо бүс эвэр юм уу модон дугтуйтай байжээ. Түүнчлэн Пазырык-5 булшинд эмээлийн шууд бүтцийн хэсэг биш боловч бүрдэл хэсэг нь болох бөс даавуун дэвсгэр-чепрак илэрсэн байдаг.

Хоёр төрлийн эмээл зэрэгцэн оршиж байсан нь хожим олон хэрэглэгдэхүүнээр батлагдаж байгаа юм. Он цагийн ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд илүү нарийн хийцтэй 2-р төрлийн эмээл пазырыкийн соёлын эхэн үе, тэр бүү хэл пазырыкийн өмнөх үед ч тохиолдож байдаг ажээ. Иймээс илүү энгийн хийцтэй 1-р төрлийн эмээл нь бие даасан хэлбэр биш харин илүү хялбаршуулсан хэлбэр байж болох юм (Кубарев, Шульга 2007: 125).

Тэгвэл Казахстаны Берелийн хоёр булшнаас (№ 10 ба 11) арав гаруй эмээлийн үлдэгдэл гарсан байдаг



Зураг 8. Скиф ба Хятад, Шинжааны зөөлөн эмээлүүд


1 – Зүүн Хань улсын үеийн хүрэл морины шугумал, Рийтберг музей, Цюрих;
2 – Их Петрийн цуглуулгад буй бүсний алтан арал дээрх эмээлтэй морьд, Эрмитаж; 3 – Субаши-I дурсгалын 10-р булшны зөөлөн эмээл, Шинжаан; 4 – Лоуланский 1-р булшны хагас зөөлөн (ясан бүүрэгтэй) эмээл, Шинжаан

(Самашев 2011: 151-156). Эдгээр эмээл бүтцийн хувьд сонгодог пазырык эмээлд хамаарах бөгөөд үнэндээ урд хойд талаасаа хударга, хөмөлд рөгөөр бэхлэгддэг эсгий тохош юм (Зураг 10). Тохшийг дээрээс нь ганц суран олмоор дарж сурын үзүүрийг нь эвэр арлаар тогтоодог байжээ. Зарим тохош нь мод юм уу эврээр хийсэн матмал нарийн нуман бүүрэгтэй байна. Үүнийг зарим судлаачид жинхэнэ утгаар нь бүүрэг гэж үзэх боломжгүй “тэлэгч” юм уу “бэхэлгээ” төдий зүйл юм гэж үздэг. Эсгий тохшийг арьс ширэн болон нэхмэл эдлэлээр хийсэн амьтдын дүртэй олон өнгийн гоёмсог наалтаар чимэглэдэг. Үнэндээ энэхүү хатуу биетэй зүйлээр хийсэн хагас дугуй-нуман хэлбэртэй зүйл бол тохшийг бие оруулж, хунирч эвхэгдэхээс


сэргийлсэн “тэлэгч” байсан бололтой.

1990-ээд онд судалсан Укодын тэгш өндөрлөгийн Ак-Алаха ба Кутургунтас дурсгалуудаас гарсан эмээлүүд (Зураг 11) пазырыкийн соёлын сонгодог эмээлээс бүтэц хийцийн хувьд онцын ялгаагүй бөгөөд зөвхөн хээ чимэглэлийн хувьд баялаг болгож байгаа юм. Үүнээс үзвэл пазырыкийн соёлын эмээлүүд нэлээд сонгодог хэлбэрээ олсон бөгөөд нэг хэв маягт хэлбэр нь тогтсон байжээ.

Пазырыкийн эмээлтэй бүтцийн хувьд ойролцоо эмээл Шинжааны түрүү төмрийн үеийн Субашийн 10-р булшнаас гарсан байдаг (Зураг 12) (Lu Enguo 1998: 255). Энэ нь түрүү төмрийн үеийн нүүдэлчдийн соёлд адуу малын тоног хэрэгсэл түгээмэл болж



Зураг 9. 1 – Пазырыкийн 1-р булшнаас гарсан эмээл (Грязнов 1950: Рис. 22),
2 – Пазырыкийн 5-р булшнаас гарсан эмээл (Руденко 1953: Рис. 128)



Зураг 10. Берелийн булшнаас гарсан эмээл-тохошнууд (Самашев 2011)

хоорондоо холбоотой ч алс холын соёлууд бий болсныг харуулж байна. Пазырыкийнхтай ижил төстэй эмээлүүд Шинжаанаар зогсохгүй Цинь Ши Хуандийн бунхны морин дээр ч ажиглагддаг (Зураг 13–3). Хятадын эдгээр олдворын он цаг пазырыкийн эмээлүүдээс арай хожуу үед хамаарах бололтой.

Хэдийгээр С.И.Руденко пазырыкийн эмээлийг ерөнхийдөө скифийн эмээлтэй адил гэж үзсэн (Руденко 1953: 161) байдаг ч Евроазийн баруун хэсгийн скифчүүдийн эмээлийн бодит олдвор байхгүй учир баттай хэлэх бололцоо муу юм. Гэхдээ эдгээр эмээлийн дүр дүрслэл нь үлдэж хоцорсон зүйлс цөөнгүй байдаг. Тухайлбал, скифийн хаадын булш болох Чертомлыкын амфор ба илдний хуйн дээрх дүрслэлийг дурдаж болно (Зураг 13–5). Энэ болон бусад олон дүрслэл бүхий скифийн олдворууд он цагийн хувьд НТӨ IV зуунаас хойш үед хамаарч буй тул пазырыкийн эмээлүүдээс хожуу үед хамаарна гэж үзэж болно.


Дээрхээс үзэхэд бидний болон бусад судлаачдын “пазырыкийн хэлбэрийн эмээл” гэж нэрлэсэн зөөлөн эмээл анх НТӨ V зуунаас хожуугүй үед Алтайд анх үүсэж улмаар Евроазийн тал нутагт түгэн дэлгэрсэн бололтой (Самашев 2011: 154). Гэхдээ хэлбэр дүрс нь бага зэрэг өөрчлөгдөн хувьссан нь ч мэдээжийн хэрэг биз ээ. Иймээс Евроазийн нүүдэлчдийн эмээлийн үүсэл ба хөгжлийн судалгаанд пазырыкийн соёлын байр суурь нэн чухал юм.

Монголын пазырыкийн булшны дотор одоогоор цорын ганц эмээлийн олдвор Олон Гүүр (нуур)-ийн голын булшнаас гарчээ. Олон Гүүр (нуур)-ийн голын 10-р дурсгалт газрын 1-р булшнаас эмээлийн эсгий дэвсний тасархай, модон хяр илэрсэн юм (Цэвээндорж, Молодин, Парцингер 2016: 30-32).

Эмээлийн эсгий дэвс. Уг дэвсийг сайн нягтаршуулсан бараан хүрэн эсгийн дээр илүү нарийн боловсруулсан шаргал туяатай цагаан саарал эсгийгээр чимэглэл хийж оёжээ. Эсгийг хоёр цагаан саарал болон улаан хүрэн хоёр өнгийн сүлжмэл утсаар бэхлэн тогтоосноос гадна ирмэгээр нь хөвөөлөн оёсон бололтой.

Эмээлийн модон хяр. Бүтэн модыг зорж хийсэн уг эдлэлийг матаж гурвалжиндуу хэлбэртэй болгосноос гадна дотор талд нь ховил гаргажээ. Хойд бүүргийн хадгалалт нь урд бүүргээс муу боловч цагаан тугалгаар бүрсэн ул мөр үлджээ.

Мөн уг модон хярын ар талаас 4 ширхэг модон товруу гарсан нь мөн л цагаан тугалгаар бүрсэн ул мөртэй байжээ. Эдгээр нь хавтгай оройтой, конус хэлбэртэй, голдоо нүхтэй юм. Ийм товруугаар хударгыг эмээлтэй бэхэлж тогтоодог байжээ. Тугалгаар бүрсний учир нь цагаан мөнгө адил гоёмсог харагдуулах зорилготой болов уу хэмээн уг дурсгалыг судалсан эрдэмтэд таамаглажээ (Цэвээндорж, Молодин, Парцингер 2016: 32).



Зураг 11. Пазырыкийн эмээлүүдийн сэргээлт (Полосьмак 1994: Рис. 42-45)

Пазырыкийн эмээлийн олмын арал. Хэдийгээр Монголын пазырыкийн соёлын булшнаас бүтэн эмээл гарсан зүйл үгүй боловч эмээлийн олмын арал байж болохуйц ясан ба эвэр арлууд цөөнгүй тоогоор гарсан юм (Зураг 15). Пазырыкчуудын олмын нэг онцлог нь олом жирмийг эмээлийн хоёр жигүүрт тус тусад нь бэхэлдэггүйтэй холбоотой юм. Энэ нь эмээлийн хавтас суудлын зөөлөвчнөөс тусдаа эд анги болоогүй буюу хатуу модон биегүй товчхондоо пазырыкийн эмээлд хавтас үүсээгүй байсантай холбоотой юм. Булшнаас илэрсэн баримт дээрх Оросын судлаачдын сэргээлтээс үндэслэвэл эмээлийн голоор эсвэл урд талаар нэг олноор даруулдаг байжээ. Хамгийн чухал нь эмээлийг морины нуруунаас холбирохоос сэргийлж байгаа бэхэлгээ буюу олмын нэг үзүүрт арлыг бөхөлж нөгөө үзүүрийг нь аралд сүвлэж түгждэг байна. Угтаа бол олом жирэм хоёр тусдаа биш нэг эдлэлийн хоёр жигүүр тус тусын үүргийг гүйцэтгэж байгаа хэрэг юм. (Шульга 2015: Рис. 38-40).

Эмээлд хатуу хавтас үүссэн үеэс олом жирэм тусдаа эд анги болж хөгжсөн бололтой байна. Монголоос илэрч олдсон олмын ясан арлуудыг хэрэглээний зориулалт, үзэгдэх дүрийг үндэслэн 1) хэлгүй ба 2) хэлтэй арал хэмээн ангилж болохоор байна.

Хэлгүй арал: Зураг 15-ын 2-5 дугаартай арлуудыг хэлгүй арлын төрөлд хамааруулж авч үзэж байна. Хэлгүй арлын хувьд тээглүүртэй (түгжээ) аралтай хавсарч сая үүргээ гүйцэтгэдэг байна. Сэргээлтээс үзвэл 1-р арал нь хэлгүй арлын түгжээний зориулалтаар олмын нэг эд анги болж оролцдог. Хэлгүй аралд хөндлөн тэнхлэгийн дагуу хос нүх гаргаад нэг нүхэнд олмын угийг бөхлөөд жирмийн үүрэгтэй үзүүрийг нөгөө нүхэнд сүвлэж жирмийн жигүүрт гаргасан нүхийг олмын дээр бэхэлсэн нөгөө арлын тээглүүрт өлгөж түгждэг байна (Шульга 2015: Рис. 38-5). Ингэж

түгжихдээ хоёр арлыг босоо тэнхлэгийн дагуу өөд өөдөөсөө угтсан байдалтайгаар тохируулан оломд бөхөлдөг ажээ. Пазырыкийн эмээлийн арлууд дотор ийм төрлийн арал мөн олон тохиолддог (Зураг 16 – 2).

Хэлтэй арал: Хэлтэй арал нь Зураг 15-ын 6-9 дугаартай арлууд юм. Тус арлууд нь дангаараа буюу өөр нэмэлт хэсэггүйгээр арлын үүрэг гүйцэтгэж чаддаг. Учир нь хэлгүй арал нь өөр нэг арлын тусламжтайгаар сая иж бүрдэл болж үүргээ биелүүлдэг билээ. Хэлтэй арлын онцлог нь хэлийг нь арлын их биеийн доод талд зорох байдлаар өөрөөс нь үүсгэн гаргаснаар дангаараа үүрэг гүйцэтгэх бололцоотой болдог. Хөндлөн тэнхлэгийн дагуу хос нүх гаргаж, босоо тэнхлэгийн дагуу дээд талд байрлах нүхэнд олмын жигүүрийн үзүүрийг бөхлөөд жирмийн үүрэг гүйцэтгэх жигүүрийн үзүүрийг арлын доод талын нүхний араас сүвлэж урагш давуулан хэлний үзүүрт түгжиж бэхэлдэг байна (Шульга 2015: Рис. 38-7).

Эдгээр олмын ясан арлуудаас үзвэл заримд хэрэглээний элэгдэл үүсэж сэв нь дарагдсан бол нөгөө хэсэг нь ямар нэгэн хэрэглээний элэгдэлгүй буюу бүтээх явцаас үлдсэн зорох, цоолборлох үеийн сэв элэгдэлгүй байна. Эндээс үзвэл тухайн арлуудыг оршуулга үйлдэх үед шинээр бүтээсэн байж болох талтай. Зураг 15-ын 4-7 дугаартай арлууд хэрэглээний элэгдэл үүсээгүй байна. Зураг 15-ын 1-3, 8, 9 дугаартай арлууд хэрэглээний элэгдлээс үүдэн сэвүүд нь дарагдсан гэж дүгнэж болохоор байна.

Дүгнэлт

Эртний нүүдэлчдийн ахуй амьдрал нийгмийн харилцааны үйлчлэл дунд адууны унаж эхэлсэн үйл явц амьдрал ахуй дунд хувьсгалын шинжтэй өөрчлөлт байжээ. Монголын өндөрлөг дэх эртний нүүдлийн соёл



Зураг 12. Субашийн 10-р булинаас гарсан зөөлөн эмээл (Шинжаан, БНХАУ)



Зураг 13. Скифийн үеийн эмээлт морины дүрслэлүүд:

1 – Пазырыкийн 5-р булшны эсгий хивсний дүрслэл; 2 – Сибирка-1 дурсгалаас илэрсэн бүсний даруулга; 3 – Цинь Ши Хуандийн онгоны шавар морь; 4 – Сибирийн цуглуулгын алтан даруулга; 5 – Чертомлыкскийн амфора дээрх морины дүрслэл



Зураг 14. Олон Гүүр (нуур)-ийн голын эмээлийн эсгий дэвс ба модон хяр, товруунууд
(Цэвээндорж, Молодин, Парцингер 2016, 114, 115, Зураг 129-133)

иргэншлийн зангилааг тайлах үндсэн ойлголтуудыг археологийн шинжлэх ухаан бий болгож байгаа билээ. Тиймдээ ч археологийн судалгааны эртний нүүдлийн мал аж ахуй тэр дундаа уналгын адууны соёлтой холбогдох олдвор хэрэглэгдэхүүн үлэмж хэмжээгээр хуримтлагдан бий болжээ. Эдгээр материалууд дээр судлаачид тухай бүрд нь үнэлэлт дүгнэлт, харьцуулалт хийж судалгааны өгүүлэл, илтгэлүүдийг нийтлүүлж,

хэлэлцүүлсээр ирсэн ч нэгтгэн дүгнэсэн нь одоогоор үгүй байна. Монгол болон хил залгаа бүс нутгаас илэрсэн нүүдэлчдийн адууны тоног хэрэгслийн судалгааг суурь судалгааны ажил болгон нарийвчлан судлах зайлшгүй шаардлага бий болжээ.

Түүнчлэн уг сэдвийг системтэйгээр ойлгохын тулд бид Монголын археологийн судалгаанд хамгийн баялаг хэрэглэгдэхүүнтэй харьцангуй эртний үед


тооцогдох пазырыкийн соёлд хамаарах уналгын адууны тоног хэрэгслийг сонгон судалж эхлээд байна. Пазырыкийн уналгын адууны тоног хэрэгсэлтэй холбоотой материал арвин төдийгүй өмнөх, дараа үеийн нүүдэлчдийн адууны соёлыг судлахад гол зангилаа болохын хувьд онцгой ач холбогдолтой. Тус соёлын оршуулгын дурсгалд дагалдуулсан адуу, тэдгээрийн тоног хэрэгсэл, зүүсгэл чимэглэлүүд нь Евразийн тал нутаг дах цаг үеийнхээ итгэл үнэмшил, урлаг соёл, харилцаа холбоо, нийгмийн харилцан үйлчлэлийн агуулгуудыг гүн гүнзгий шингээсэн, цаг үеэ төлөөлж чадахуйц өргөн хүрээний утга агуулгыг багтаасан хэмээн үзэж болно.

Пазырыкийн уналгын адууны тоног хэрэгслийн хэлбэр, агуулга нь нүүдэлчдийн адууны тоног хэрэгслийн өөрчлөлт хувьслын маш тодорхой жишээнүүдийг агуулж байдаг. Тэр дундаа адууны тоног хэрэгслийг чимэглэдэг амьтны загварт урлагийн хэд хэдэн төрөлт дүрүүд тухайн ард түмэн төрт ёсны бэлгэдэл, сүсэг бишрэл, итгэл үнэмшил, соёлын түвшин, үйлдвэрлэлийн чадвар зэргийг илэрхийлэх боломжтой юм.

Монгол нутагт малтан судлагдаад байгаа пазырыкийн дурсгалуудаас илэрсэн адууны тоног хэрэгсэлд бүс нутгийн хүрээнд анхан шатны боловсруулалтуудыг хийж, хэрэглэгдэхүүн тус бүрээр



Зураг 15. Монголын пазырыкийн булинаас гарсан олмын арлууд



Зураг 16. Пазырыкийн олмын арлыг бэхлэх хэлбэрүүд (Степанова 2005: Рис. 1)

нь зүйлчлэн бичсэн. Өөрөөр хэлбэл, пазырыкийн уналгын адууны тоног хэрэгсэл бүхлээр нь нэг бүлэг болгон авч үзэв. Тухайн бүлэг дотор хазаарыг нэгэн дэд сэдэв болгож амгай, зуузай, сур, чимэглэл хэмээн сэдвийг дотор нь зүйлчлэн бичсэн. Ингэхдээ амгай зуузайнд материал, хэлбэрийн хувьд тойм ангиллууд хийж Орос, Казахстан, Хятадын Алтайн ижил хэрэглэгдэхүүнүүдтэй харьцуулалт хийлээ. Дараагийн дэд сэдэв нь эмээл түүний дагалдах эд ангийн тухай юм. Эмээлийн тухайд Монголоос илэрч олдсон хэрэглэгдэхүүн Олон Гүүр (нуур)-ын голын 10-р дурсгалт газрын 1-р булшнаас илэрсэн эмээлийн зарим эд ангиас өөр материал хараахан үгүй байна. Тиймээс Орос Алтай, Казахстаны Алтай, Хятадын Шинжаанаас илэрсэн эмээлийн материалууд дээр тулгуурласан. Дэд сэдэвт эмээлийг хэлбэрийн хувьд бүхлээр нь 2 ангилж тодорхойлсон С.И.Руденкогийн тодорхойлолт дээр үндэслэлээ боловсруулав. Мөн Монголын өндөрлөгөөс илэрсэн пазырыкийн эмээлийн олмын ясан арлуудад ангилалт хийж үүрэг зориулалтыг тодорхойлон нэгэн зүйл болгосон нь цааш үргэлжлүүлэх нэгэн чухал сэдэв юм. Пазырыкийн эмээл нь Скикийн соёлын эмээлийн гол төлөөлөл болохын зэрэгцээ хамгийн чухал нь одоогоор бодитоор олдоод байгаа хамгийн эртний эмээл гэдгийг тодотгосон хэрэг юм. Пазырыкийн эмээл нь одоогоор байгаа хамгийн эртний эмээлээс гадна зөөлөн биетэй эмээлийн гол төлөөлөгч болохын хувьд эмээлийн өвөг шинж чанарыг хадгалсан биет олдвор гэдэг нь нэн сонирхолтой. Эмээлийн судалгааны гол ойлголт пазырыкийн зөөлөн эмээлийн төрөл, бүрдэл хэсгүүдийг хил залгаа бүс нутаг, соёлын хамаарлаар нэгтгэн авч үзсэнээр эмээлийн үүсэл хөгжил, хувьсал өөрчлөлтийн зургийг гаргах бололцоо бүрдэж байна. Өөр нэгэн дүгнэлт бол Евразийн тал нутагт зөөлөн эмээлийн хэрэглээ пазырыкийн соёлоос эх авч тархсаныг илэрхийлсэн хэрэг юм.

Пазырыкийн эмээлийн судалгаа бол нүүдэлчдийн төдийгүй Евразийн өргөн уудам газар адууны соёлын цөм судалгааны тулгуур ойлголт юм. Тиймдээ ч эмээлийн судалгаанд онцгой ач холбогдол өгч байгаа билээ. Энэ судалгаанд пазырыкийн эмээлийн баримтуудыг нэг дор нэгтгэн тайлбарласныг онцолж байна. Нүүдлийн соёл иргэншлийн том төлөөллүүдийн хувьд адууны соёлд хамгийн чухал ач холбогдол бүхий эмээлийн хэрэглээний орон зайг тогтоох нэг асуудал бий.

Abstract

Horse equipment of the Pazyryk culture of Mongolia

Dunburee Batsukh & Ganbold Enkhbayar

In this date 50 burial structures of the Pazyryk culture were excavated in the western region of the Mongolian Altai Mountains between 2005 and 2018. This research focused on examining the riding horse equipment unearthed from these structures. The significance of this study lies in its ability to provide a comprehensive overview of a specific aspect of the Pazyryk culture in the Mongolian Altai region, achieved through comparative analysis with riding horse equipment discovered in adjacent regions. This comparative approach offers valuable insights into the regional variations and cultural nuances within the broader context of the Pazyryk culture.

Furthermore, this research serves as a foundation for future investigations aiming to elucidate the broader significance of the documented artifacts and materials. Specifically, it has the potential to contribute significantly to the understanding of ancient nomadic horse culture. By building upon this groundwork, scholars can further explore and interpret the multifaceted aspects of horse-related practices, technologies, and symbolism prevalent among the ancient nomadic societies inhabiting the Eurasian steppes.

Ном зүй

Амброз, А.К. (1973). Стремена и седла раннего средневековья как хронологический показатель (IV-VIII вв.). СА, 1973, № 4: 81-98.

Амброз, А.К. (1979). [Приложение] К статье А.В.Дмитриева - Погребения всадников и боевых коней в могильнике эпохи переселения народов на р. Дюрсо близ Новороссийска. СА, 1979, № 4: 229-231.

Грязнов, М.П. (1950). Первый Пазырыкский курган. – Л.: Изд-во Гос. Эрмитажа, 1950. – 92 стр.

Дмитриев, А.В. (1979). Погребения всадников и боевых коней в могильнике эпохи переселения народов на р. Дюрсо близ Новороссийска. – СА, 1979, № 4: 212-229.

Засецкая, И.П. (1994). Культура кочевников южнорусских степей в гуннскую эпоху (конец IV-V вв.). – СПб., 1994. – 224 стр.

Коновалов, П.Б. (1976). Хунну в Забайкалье. Улан-Удэ: АН СССР. Сиб. отд-ние. Бурят, фил. Ин-т обществ. наук, 1976. – 221 стр.

Кубарев, В.Д., Шульга, П.И. (2007). Пазырыкская культура (курганы Чуи и Урсула). Барнаул: Изд. АГУ, 2007. – 282 стр.

Марсодолов, Л.С. (1998). Основные тенденции в изменении форм удила, псалиев и пряжек коня на Алтае в VIII-V вв. до н.э. Снаряжения верхового коня на Алтае в раннем железном веке и средневековья. – Барнаул: Изд. АГУ, 1998: 5-24.

Марсодолов, Л.С. (2012). Новые материалы о связях Саяно-Алтая с Анатолией, Монголией и Китаем в I тыс. до н.э. Homo Eurasiaticus в духовных и социальных реалиях времени. – СПб.: СПб. ГИЭУ, 2012: 83-107.

Очир-Горяева, М.А. (2012). Древние всадники степей Евразии. – М.: ТАУС, 2012. – 472 стр.

Полосьмак, Н.В. (2001). Всадники Укока. – Новосибирск: Инфолио-Пресс, 2001. – 336 стр.

Руденко, С.И. (1948). Второй Пазырыкский курган. Результаты работ экспедиции ИИМК АН СССР в 1947 г. Предварительное сообщение. – Л.: Изд-во Гос. Эрмитажа, 1948. – 64 с. + 29 табл.

Руденко, С.И. (1953). Культура населения Горного Алтая в скифское время. – М.-Л.: Изд. Академии наук СССР, 1953. – 402 стр., Табл. CXVIII.

Руденко, С.И. (1960). Культура населения Центрального Алтая в скифское время. – М.-Л.: Изд. Академии наук СССР, 1960. – 359 стр., Табл. CXXVIII.

Самашев, З. (2011). Берел. – Алматы: Изд. Дом «Таймас», 2011. – 236 стр.

Степанова, Е.В. (2005). Эволюция подпругных застёжек по материалам курганов Алтая скифского времени. Снаряжение кочевников Евразии. Сборник научных трудов. Отв. ред. А.А.Тишкин. – Барнаул: Изд. АГУ, 2005: 109-115.

Степанова, Е.В. (2006). Эволюция конского снаряжения и относительная хронология памятников пазырыкской культуры. – Археологические вести, № 13: 102-150.

Степанова, Е.В. (2014а). Китайские седла III в. до н.э. – III в. н.э. Труды IV (XX) Всероссийского археологического съезда в Казани. Том II. – Казань: Отечество, 2014: 235-240.

Степанова, Е.В. (2014б). Скифские седла и последствия верховой езды для лошади и всадника в скифское время. – АС, Вып. 40 (Материалы и исследования по археологии Евразии): 125-242.

Степанова, Е.В. (2015а). Седла гунно-сарматского времени. Труды Государственного Эрмитажа. Том 77. Археология без границ: коллекции, проблемы, исследования, гипотезы. – СПб.: Изд. Гос. Эрмитажа, 2015: 389-425.

Степанова, Е.В. (2015б). Скифские седла и последствия верховой езды для лошади и всадника в скифское время. – Государственный Эрмитаж: Археологический сборник, Вып. 40: 125-142.

Таскин, В.С. (1968). Материалы по истории сюнну (по китайским источникам). Предисловие, переводы

примесания В.С.Таскина. – М.: Изд. Наука, 1968. – 176 стр.

Тишкин, А.А., Горбунова, Т.Г. (2004). Методика изучения снаряжения верхового коня эпохи раннего железа и средневековья. Учебно-методическое пособие. – Барнаул: Изд-во АГУ, 2004. – 126 стр.

Тишкин, А.А., Матренин, С.С. (2017). Детали конской узды из курганов хуннского времени памятника Яломан-II (Центральный Алтай): хронологический аспект. Труды V (XXI) Всероссийского археологического съезда. Том II. – Барнаул: Изд-во АГУ, 2017: 124-128.

Цэвээндорж, Д., Молодин, В.И., Парцингер, Г. (2016). Монгол Алтайн пазырыкийн соёлын цэвдэгт булш. – УБ.: ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, 2015. – 267 тал.

Шульга, П.И. (2015). Снаряжение верховой лошади в Горном Алтае и Верхнем Приобье. Часть II (VI–III вв. до н. э.). – Новосибирск: РИЦ НГУ, 2015. – 322 с.

Фодор, И. (2017). К вопросу о погребальном обряде гуннов Восточной и Центральной Европы. – Крадин, Н.Н., Ситдинов, А.Г. (Ред.) III Международный конгресс средневековой археологии евразийских степей “Между Востоком и Западом: движение культур, технологии и империй”. – Владивосток, 2017: 267-272.

Bóna, I. (1991). Das Hunnenreich. – Stuttgart: Konrad Theiss Verlag, 1991. – 294 pp.

Crump, J.I. (1970). Chan-Kuo Ts'ue. Translated by J.I.Crump. – London: Oxford University Press, 1970. – 602 pp.

Goodrich, C.S. (1984). Riding Astride and the Saddle in Ancient China. – in: HJAS, Vol. 44 (2): 279-306.

Goodrich, C.S. (1986). The Saddles of the Bronze Horses of Lei-t'ai. – in: Journal of American Oriental Society, Vol. 106(1): 41-48.

Istvánovits, E., Kulcsar, V. (2014). New Find of Hun Age Saddle Plates from North-East Hungary. Csis, S. (Hrsg.) Archäologische Beiträge. Gedenkschrift zum hundertsten Geburtstag von Kurt Horedt. – Cluj-Napoca: Mage Verlag, 2014: 269-278.

Linduff, K.M., Robinson, K.S. (2022). Pazyryk Culture Up in the Altai. – London and New York: Routledge, 2022. – 157 pp.

Lu Enguo (1998). Harness. in: Feng Yue, Ma Chengyuan (Ed.) Archaeological Treasures of the Silk Road in Xinjiang Uygur autonomus region. – Shanghai: Shanghai Translation Publishing House, 1998. – 321 т. (хятад хэлээр)

Selbitschka, A. (2010). Prestigegüter entlang der Seidenstrasse? Archäologische und historische Untersuchungen zu Chinas Beziehungen zu Kulturen des Tarimbeckens von zweiten bis frühen fünften Jahrhundert nach Christus. Asiatische Forschungen 154. – Wiesbaden:

Harrassowitz Verlag, 2010. – 739 pp.

Van Driel-Murray, C., Connolly, P. & Duckham J. (2004). Roman Saddles: Archaeology and Experiment 20 Years on. in: Guilmor, L. (Ed.) In the Saddle. An Exploration of the Saddle through History. – London: Archetype Publications, 2004: 1-19.

Батболд, Н., И Сан Жун. (2016). Монголын соёлын өвийн судалгаа VI. – БНСУ, Хёндо Обсед хэвлэлийн газар, 2016, тал 331.

Received: Apr 9, 2024; Revised: Apr 23, 2024; Accepted: May 1, 2024

